

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

Нэг. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын албаны хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Ажлын албанаас 2019 оны 04 дүгээр сард ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 1 удаа болж, 8 асуудал хэлэлцэн 5 тогтоол, 2 тэмдэглэл гаргасан. **Тэргүүлэгчдийн VI-р Хуралдаанаар:**

1. Олон хүүхэд төрүүлж өсгөж “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулах хүсэлт уламжлах тухай асуудлыг хэлэлцээд 27 сумын 448 эхийн материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

2. Аймгийн 2019 оны төсвийн 1-р улирлын гүйцэтгэл, аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр хуралдааны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцыг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр аймгийн Засаг даргад үүрэг өгөв.

3. Батсүмбэр сумын гүүрийн засварын ажлын зураг төсөв хийлгэх тухай асуудлыг хэлэлцээд уг ажлыг гүйцэтгүүлэхийг зөвшөөрч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 13 дугаар хуралдаанд өргөн мэдүүлэхийг аймгийн Засаг даргад даалгав.

4. Аймгийн хаврын тариалалтын бэлтгэл ажлын явцыг хэлэлцээд холбогдох шийдвэрүүдийн хэрэгжилтийг үе шаттай хангах талаар хуралдааны тэмдэглэлээр аймгийн Засаг даргад үүрэг өгөв.

5. “Томоко” ОНӨААТҮГ-ын өмчийн хэлбэрийг өөрчлөх тухай, хөрөнгийг шийдвэрлэх тухай асуудлуудыг хэлэлцээд тус газар нь байгуулагдсан цагаас хойш тогтвортой үр ашигтай ажиллаж чадахгүй байгаа, үйл ажиллагааг нь тогтмолжуулан, үргэлжлүүлэх талаар Япон улсын Тотори мужийн саналыг үндэслэн хамтарсан аж ахуйн нэгж байгуулах замаар хувьчлах тухай аймгийн Засаг даргын саналыг дэмжиж “Томоко” ОНӨААТҮГ-ыг хамтарсан үйлдвэрийн газар байгуулах замаар хувьчлах тухай” тогтоолыг батлав.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж 12 асуудлыг хэлэлцэн холбодох шийдвэрийг гарган ажилласан.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/160 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг хуралдаж “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” захирамжийн төслийг хэлэлцэн 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/221 дүгээр захирамжаар батлуулав.

Аймгийн ЗДТГ-ын 2019 оны нэгдсэн төлөвлөгөөний 1 дүгээр улирлын биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 74.66%-ийн хэрэгжилттэй байна.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2019 оны 01 дүгээр улирлын мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт аймгийн Засаг даргын орлогчийн 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01/673 тоот албан бичгээр хүргүүллээ.

Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын 3.1.1-д заасны дагуу “Иргэдтэй уулзах цаг”-ийг Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд “Лхагва” гараг бүрийн 10:00-13:00 цагийн хооронд зохион байгуулж байна. Өссөн дүнгээр 11 удаагийн уулзалтаар давхардсан тоогоор 87 иргэний 146 санал, хүсэлт, гомдол, асуулт, шүүмжлэлийг хүлээн авч 27 санал, хүсэлт, асуултын хариуг иргэнд шууд өгч, шийдвэрлэлт 74,15% байна.

27 сумын 97 багийн Засаг даргын судалгаа шинэчлэн гаргалаа. Мөн сумын Засаг дарга, орлогч дарга, багийн Засаг дарга, сумын ЗДТГ-ын архив албан хэрэг хөтлөлтийн ажилтан, олон нийтийн интернет мэдээллийн төвийн ажилтнуудын албан тушаалын

тодорхойлолтыг тус тус боловсруулж, сумдад хүргүүлсэн. Хэлтсийн албан тушаалуудын тодорхойлолтыг боловсруулж, холбогдох ажлын хэсэгт хүргүүлээд байна.

Эрдэнэ сумын Засаг даргыг томилох ажиллагааг зохион байгуулж, ажил хүлээлцүүлэн “Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, түүнийг дагаж мөрдөх дүрэм журам” сэдвийн хүрээнд 20 албан хаагчид сургалт явууллаа.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу Явуулын багийн төвийн тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулах ажлыг тендерт шалгарсан байгууллагатай хийсэн.

Удирдлагын академитэй хамтран “Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй” сэдэвт сургалтыг аймгийн ЗДТГ болон хэлтэс, агентлаг, байгууллагын нэгж, албадын дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд явуулж, гэрчилгээ олгосон.

2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Монголын Улс төр, бизнесийн удирдлагын академийн сонсогч 15 оюутанд аймгийн ЗДТГ-тай танилцах дадлагыг зохион байгуулж, бүтэц, үйл ажиллагаа, аймаг орон нутгаас баримталж буй бодлого, зохион байгуулж буй цаг үеийн ажлын талаар мэдээлэл өгч ажиллаа.

2019 оны 4 дүгээр сарын байдлаар аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 30 иргэн, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 40 иргэнийг шагнаж, урамшууллаа.

Аймгийн ЗДТГ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, ажиллах журам, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.

Тайлант хугацаанд 2 удаагийн цахим хурал, 9 удаагийн танхимын хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтын үеийн техникийн хэвийн ажиллагааг хангаж, Дотоод удирдлагын системийн ашиглалтын талаар 10 зааварчилгаа бэлтгэн ТАХ-дад хүргүүлсэн.

Төрийн албаны стандартын хүрээнд: Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын хүрээнд 26 сум, 12 байгууллагын 194 төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдэл олгуулах саналыг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, аймгийн Засаг даргад санал хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

Мал аж ахуйн хаваржилт, мал төлөлт эхэлсэнтэй холбогдуулан төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор малчин өрх /эмээ өвөө, эцэг эх/-үүдэд хөдөлмөрийн тусламж дэмжлэгийг цаг алдалгүй хүргэхээр Салбар зөвлөлөөс 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 18 дугаар албан бичгийг хүргүүлж, мал бүхий албан хаагчдад ажлын 3-5 хоногийн цалинтай чөлөө олгуулах чиглэл өглөө.

Төрийн албаны зөвлөлийн ирүүлсэн чиглэлийн дагуу хүний нөөцийн нэгдсэн судалгааг аймгийн хэмжээгээр гарган хүргүүлсэн.

Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдад монгол хэлний найруулга зүй, журамласан үгсийн талаарх сургалтыг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Болосврол соёл, урлагийн газартай хамтран 2019.04.26-ны өдөр зохион байгууллаа.

Салбар зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2019.04.26-ны байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	8
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	1
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	-
5	Төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар	-

6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	-
НИЙТ ДҮН		9

2019 оны 04 дүгээр сарын 26-ны байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй
1	Албан бичиг	153	17	17	-
2	Өргөдөл, гомдол	9	8	5	3

Гадаад харилцаа: БНСУ-ын Кангвон мужид 2019 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр гарсан Гал түймрийн хохирлыг барагдуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор харамсал илэрхийлж, хандивын аяныг аймгийг хэмжээнд өрнүүлж байна.

БНСУ-ын Кёнсанбук хотод үйл ажиллагаа явуулдаг Зүүн Хойд Азийн нутгийн захиргааны холбооноос 2019 оны 4 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хуралд аймгийн төлөөлөл оролцов.

БНСУ-ын Кангвон мужийн Хөдөө аж ахуйн техник технологийн хүрээлэнд 2019 оны 4 дүгээр сарын 7-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Хүлэмжийн тариалалтын сургалт”-д аймгаас 7 агрономч хамрагдлаа.

БНСУ-ын Захирагч нарын Холбооны 2019 оны тэтгэлэгт К2Н хөтөлбөрт аймгийн Статистикийн хэлтсийн статистикч С.Батбаярыг 2019 оны 4-р сараас 6 сарын хугацаатай суралцуулж эхэлсэн.

БНХАУ-ын Жилинь мужид болсон 2019 оны “Төрийн албан хаагч солилцооны тэтгэлэгт хөтөлбөр”-т Эрдэнэсант сумын Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн мэргэжилтэн Л.Атарбаярыг 2019 оны 3-р сараас 1 жилийн хугацаатай суралцуулж эхэллээ.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 2019 оны 04 дүгээр сарын 26-ны байдлаар Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт 26 байгууллага 330 гаруй төрлийн үйлчилгээг 7000 орчим иргэнд, өдөрт дунджаар 300-400 иргэнд шуурхай хүргэн ажиллаа.

Аймгийн веб сайтад 40 мэдээ мэдээлэл, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд 77 мэдээ мэдээлэл нийтлэгдсэн. 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн 4 дугаар, мөн бусад телевизүүдийн мэдээний цагаар давтагдсан тоогоор нийт 48 мэдээ мэдээллийг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэлээ.

7 хоног бүрийн “Лхагва” гаригийн 10:00-13:00 цагийн хооронд аймгийн удирдлагууд 23 иргэнтэй уулзаж, 31 санал хүсэлт хүлээн авсан. Харин 7027-1111 нээлттэй утсанд төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой 8 гомдол санал ирснийг холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлэв.

Тайлант хугацаанд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудын ЗДТГ-ын төлөөлөл ТҮНТ-ийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: 2019 оны 04.01-05.01-ний хооронд “Эрүүл аюулгүй орчин-Таны оролцоо” сарын аян зохион байгуулсантай холбогдуулан 2019.04.04-ний өдөр аяны нээлтийг хийж, Хөдөлмөр, Эрчим хүч, Байгаль орчин, Барилгын техникийн чиглэлээр тус тус мэдээлэл хийсэн. Нээлтийн үйл ажиллагаанд аж ахуйн нэгжүүдийг төлөөлөн 118 ажилтан, албан хаагчид оролцож 850 гаруй боршур, зөвлөмж, сэрэмжлүүлгийг тарааж ажиллалаа.

Тус газар нь төлөвлөгөөт хяналт шалгалт 41, төлөвлөгөөт бус шалгалт 8, хяналт шинжилгээ 2, урьдчилан сэргийлэх хяналт 8, баталгаажуулах үйл ажиллагаа 1 тус тус хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага 22, акт 4, зөвлөмж 8, дүгнэлт 11 үйлдэж хяналт шалгалтад хамрагдсан иргэн аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж ажилласан.

Иргэн Ж.Хосбаяраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Зуунмод сумын 1 дүгээр багийн 13 дугаар байрны залгаа 0 тоотод байрлах “ZMX” цахим тоглоомын газрын үйл ажиллагаанд баталгаажуулалтын хяналтыг хийлээ.

Өнгөрсөн сард төлөвлөгөөт хяналт шалгалт, ААН иргэний хүсэлтийн хүрээнд 183 сорьцыг шалган хүлээн авч 1085 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан олгосон. Шинжилгээгээр 38 сорьц 75 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй гарсан. Тус лабораторид шинжилгээний LIMS программд холбогдох ажил явагдаж байна.

Онцгой байдлын газрын хүрээнд: 2019 оны 4 дүгээр сард Газрын ёс журам сахиулах эргүүлээр ажиллах хуваарийг газрын даргаар батлуулан хуваарийн дагуу газрын офицер бүрэлдэхүүн газрын ёс журам сахиулах эргүүлийн үүргийг гүйцэтгэсэн. Нийт бие бүрэлдэхүүн 7 хоног бүрийн ажлын өдрүүдэд өглөөний 07 цагт газрын спорт зааланд биеийн ерөнхий хөгжлийн дасгалыг тогтмол хийж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдөр батлагдан гарсан “Үзвэр үйлчилгээ, соёл урлагийн байгууллага”, “Эрүүл мэндийн” байгууллага”-уудад галын аюулгүй байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах биелэлтийн хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Зуунмод сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон хувийн эмнэлгийн барилга байгууламж соёл, урлагийн байгууллагад хяналт шалгалт хийсэн.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 22 байгууллага, аж ахуйн нэгжид шалгалт хийж, гамшиг осол гал түймэр гарч болзошгүй 84 зөрчил дутагдал илрүүлэн, газар дээр нь 32 зөрчлийг засуулан 52 зөрчилд Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх 13 албан шаардлага бичиж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Галын аюулгүй байдал нь хангагдсан 55 аж ахуй нэгж, байгууллагад ажлын байрны дүгнэлт олгосон.

Улсын онцгой комиссын 01 дүгээр албан даалгавартай холбогдуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар Аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгаварын дагуу 27 сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын сургалтыг Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулав.

Тайлант хугацаанд “Бэлэн бай”, “Галын аюулгүй байдал” сэдэвт сургалтад 442 иргэн, албан хаагчийг хамруулж, 100 гаруй айл өрхөд ухуулах сэрэмжлүүлэх материал тараалаа.

Мөн хугацаанд ой хээрийн 2, объектын 4 гал түймэр гарсныг ОБГ-ын алба хаагчид болон орон нутгийн иргэд, техникийн хүчээр унтраав. Хүчтэй салхи шуурганы улмаас 6 өрхийн гэр нурч, тэсэрч дэлбэрэх ажиллагааны улмаас 1 иргэний амь нас эрсдсэн байна.

Гурав. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлого, зарлагын сар улирлын хуваарийг аймгийн Засаг даргын 2019 оны А/32 дугаар захирамжаар батлуулж, хэрэгжилтийг хангаж байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 279,0 сая төгрөгөөр тасарсантай холбогдуулж аймгийн ЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2019 оны А/157 дугаар захирамжаар байгуулж, татварын орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэх 2 сарын аяныг 3 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн зохион байгуулсан. Аяны үр дүнд 3 дугаар сарын аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 102,8 хувь буюу 102 сая төгрөгөөр давж биелэв.

2019 оны эхний 1-р улирлын байдлаар аймгийн орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 4449.3 сая төгрөг оруулахаас 4750.1 сая төгрөг оруулж, төсвийн орлогын төлөвлөгөө 300.8 сая төгрөг буюу 106.7 хувиар биелэсэн.

Сумдын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 126.1 хувь буюу 198.7 сая төгрөг, аймгийн төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 102.8 хувь буюу 102.0 сая төгрөгөөр тус тус давж биелэсэн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзвэл сумдын төсвийн орлогоос суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгах татвар, тэмдэгтийн хураамж, ойн төлбөрийн орлогууд тасарсан байна. Баян, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Лүн, Эрдэнэ, Зуунмод сумд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тасалдуулжээ. Аймгийн төвлөрсөн төсвийн орлогоос газрын төлбөр, цалингийн ашгийн албан татвар, түрээсийн орлогын төлөвлөгөө тасрав. Аймгийн төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Баян, Баянжаргалан, Борнуур, Сүмбэр, Угтаалцайдам, Эрдэнэ сумд биелүүлээгүй байна.

04 дүгээр сарын 25-ны өссөн дүнгээр нийт 22.325.766,5 мянган төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон. Салбараар нь авч үзвэл:

- Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 10.920.646,6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:
 - Ерөнхий боловсролын сургуулиудад 7.499.041,4 мянган төгрөг
 - Хүүхдийн цэцэрлэгт 3.421.605,2 мянган төгрөг тус тус олгоод байна.
- Эрүүл мэндийн сайдын багцаас 2.834.693,6 мянган төгрөгийг олгосон.Үүнд:
 - Сумдын эрүүл мэндийн төвд 2.755.427,8 мянган төгрөг
 - Өрхийн эмнэлэгт 79.265,8 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.
- Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 176.038,7 мянган төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 103.065,7 мянган төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.
- Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 8.291.321,9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:
 - Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 5.149.899,9 мянган төгрөг
 - Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 2.469.989,0 мянган төгрөг
 - ОНХСангуудад 671.433,0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгосон.

2019 оны 04 дүгээр сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр сум, төсөвт байгууллагууд нийт 106,665.7 мянган төгрөгийн авлага, 498,597.5 мянган төгрөгийн өглөгтэй байна. Нийт өглөгийн 361,925.6 мянган төгрөг буюу 72.6 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 38,045.9 мянган төгрөг буюу 7.6 хувь нь цалингийн зардал, 36814.6 мянган төгрөг буюу 7.4 хувь нь гэрэл, цахилгааны зардал, 16,904.4 мянган төгрөг буюу 3.4 хувь нь эмийн зардал, 12,903.1 мянган төгрөг буюу 2.6 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр, үлдсэн 32,003.9 мянган төгрөг буюу 6.4 хувийг бусад зардлын өглөгүүд тус тус эзэлж байна.

Дөрөв. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

Хууль сурталчлах сарын ажлын хүрээнд 4 сард байгаль орчны холбогдолтой хууль журам сурталчлах 14 хоногийн ажлыг аймаг, сум, байгууллагын хэмжээнд зохион байгуулж байна.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 62 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж өгч, хууль, эрх зүйн асуудлаар 64 иргэн, байгууллагад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлсэн.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд Баяндэлгэр, Бүрэн, Зуунмод, Заамар сумдад “Өсвөрийн сэргийлэгч-Бидний оролцоо” сэдэвт “Хуулиа дээдэлъ” тэмцээнийг бүсчилсэн зохион байгуулахад 26 сумын 270 гаруй сурагч хамрагдлаа. Мөн тус зөвлөлөөс Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран “Замын хөдөлгөөний цагаан толгой-2019” тэмцээнийг 5 сумын 10 цэцэрлэгийн 120 хүүхдийг хамруулан Зуунмод хотноо 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа.

Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газруудын согтууруулах ундаа худалдаалах, түүгээр

үйлчлэх цагийн хязгаар тогтоосон аймгийн Засаг даргын 2018 оны А/340 дүгээр захирамжийг дэмжих эсэх асуудлаар Зуунмод сумын 6 багт 04 дүгээр сарын 17-ны өдөр хэлэлцүүлэг өрнүүлж, санал асуулга авч ажилласан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулж, холбогдох шатны хурлуудаар хэлэлцүүлж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/23 тоот тушаалаар “Нууц хамгаалах журам”, “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”, “Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт”, аймгийн Засаг даргын А/220 тоот захирамжаар “Аймгийн хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах 2019 оны төлөвлөгөө”-г баталж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүллээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг угтаж аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний асуудал хариуцсан хэлтэс, агентлагийн дарга, нэгжийн менежерүүдийн бүрэлдэхүүнтэй сургалт, мэдээлэл авах ажиллагааг Архивын Ерөнхий газарт зохион байгуулсан.

Архивын үйлчилгээ: Тайлант хугацаанд архивын эх баримтаас 282 иргэний хүсэлтээр 399 хуулбар хувь, 116 лавлагаа гарган үйлчилсэн бөгөөд 934.500 төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэв.

2 хөмрөгийн 197 хадгаламжийн нэгжийн 6792 хуудас баримтын 21929 хүний нэр, 6115 заалтын тоо, 6115 тушаалын тоон мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж PDF.JPEG хэлбэрт хувиргав. Мөн 2 хөмрөгийн 197 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийсэн.

Улсын бүртгэлийн үйлчилгээ: 2019 оны 04 дүгээр сарын байдлаар эд хөрөнгийн бүртгэлийн цахим санд нийт 49379 хувийн хэрэг байгаагаас үл хөдлөх /газраас бусад/ - 9438, Газар өмчлөх эрхийн -39941 хувийн хэрэг байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 16803. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 65.7 сая төгрөг, үл хөдлөх худалдан борлуулсны орлогоос 25.5 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 1.9 сая төгрөгийг тус тус улсын төсөвт орууллаа.

Тайлант хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 90 аж ахуй нэгж, байгууллага бүртгүүлж, 58 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 10, хууль хяналтын байгууллагад 18 лавлагаа мэдээлэл өгч, 4.2 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг орон нутгийн төсөвт орууллаа.

Цагдаагийн газрын ажил ажиллагааны хүрээнд: 3 дугаар сард 49 холбогдогчтой, 566.900.000 төгрөгийн хохиролтой **130** гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25 хэргээр буюу **19,2** хувиар өссөн байна.

Хөнгөн гэмт хэрэг 101 бүртгэгдсэн нь 31 нэгжээр буюу 30,7 хувиар, хэрэг бүртгэлтийн гэмт хэрэг 91 бүртгэгдэж 9 нэгжээр буюу 9,9 хувиар, мөрдөн байцаалтын гэмт хэрэг 39 бүртгэгдэж 16 нэгжээр буюу 41,0 хувиар тус тус өссөн, хүнд гэмт хэрэг 29 бүртгэгдсэн нь 6 нэгжээр буюу 17,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн үйлдэгдсэн байдлаас үзэхэд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 26,7 хувиар, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 56,2 хувиар, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 75,0 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэг 100,0 хувиар тус тус өссөн, аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг 33,3 хувиар буурсан, галт зэвсэгээр үйлдэгдсэн гэмт хэрэг, хүүхэд оролцсон гэмт хэргүүд урьд оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

Тус аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 27,5 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,1 хувиар өссөн. Улсын дундаж 12,9 хувьтай гарсан ба Улсын дунджаас 14,6 хувиар өссөн дүнтэй байна.

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн page хуудас, Нийслэлийн Цагдаагийн газрын page хуудсанд тавигдсан “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье” аяны хүрээнд “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Автомашинны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Хулгайчид боломж бүү олго, та сэргийлж чадна”, “Хулгайчаас салцгаая”, “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэхэд техник, технологийн дэвшлийг ашиглах нь “Халуун сэдэв”, нэвтрүүлэг, “Хулгайгаас сэргийлье”, “Халаасны хулгай”, “-С Градус” гэх мэт нэвтрүүлэг, видео, шторк, постерийг хандалт ихтэй 28 группэд share хийж байршуулан 519.796 иргэнд хүргэсэн.

Гудамж талбай, олон нийтийн газар болон гэр орон, ахуйн хүрээндээ архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгслэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон, шүүхээр баривчлагдсан, албадан саатуулагдсан нийт 78 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд хүлээн авснаас эрүүлжүүлэгдсэн-38, албадан саатуулсан-11 шүүхээр баривчлагдсан-29 иргэний биед үзлэг хийсэн. Эрүүлжүүлэгдсэн иргэдээс нийт 408.500 төгрөг буюу 100% төрийн сангийн дансанд тушаасан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 46 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 9 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, ЦЕГ-ын туслах тоо бүртгэлд мэдээллийг оруулсан.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5446 жолоочийг 175.175.000 төгрөгөөр торгосон.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Тайлант хугацаанд Криминалистикийн шинжилгээ-85, магадлан шинжилгээ-66, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-166, гарын мөрийн санг баяжуулсан-65, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 245 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
04-р сар	398	217	8	607	187	420	30.8%
	3920610.2	2241949.4	450956.1	5711603.5	989603.0	4722000.5	

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

Мерит төсөлтэй хамтран төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд 23 сумын 24 нийгмийн бодлогын мэргэжилтэнд “Жендэрийн бодлого, төлөвлөлт болон нийгмийн салбарын бодлого төлөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх нь” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгуулав.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян”-ы хүрээнд аймгийн ХАБЭА-н салбар зөвлөлөөс хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл, аюулгүй амьдрах арга барил, зан үйлийг төлөвшүүлэх сургалтыг 3 сургууль, 1 МСҮТ-ийн 116 хүүхдэд явуулсан.

Хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, тэднийг бүжгийн спортоор дамжуулан хөгжих, авьяас чадварыг нээх зорилгоор “Цагаан сарнай 2019” бүжгийн спортын тэмцээнийг Монгол

Туургатан театр, Монголын бүжгийн спортын холбоо, ДЗМОУБ-ын Төв ОНХ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран зохион байгуулж 19 сумын 48 баг 418 сурагч амжилттай оролцлоо.

Нийгмийн бодлогын хэлтсийн нэрэмжит нийгмийн салбарын байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд “Нөхөрсөг тэмцээн”-ийг анх удаа зохион явуулж, 11 байгууллагын 10 багийн 120 гаруй тамирчид оролцов.

Нийгмийн салбарын “НЭЭЛТГЭЙ ХААЛГА”-ны өдөрлөгийг Зуунмод сумын Ланс багт зохион байгуулж, багийн 53 өрхөөр орж, иргэдтэй уулзаж, санал хүсэлтийг сонсон, мобайл технологиор эрүүл мэндийн үзлэгийг газар дээр нь үзүүлэн сэтгэл ханамжийн судалгаа авч, салбарын үйлчилгээг цогц байдлаар хүргэлээ.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: Монголын багш нарын VII их хурал 2019 оны 4 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд Төрийн ордонд “Сайн багш сайхан ирээдүй” уриан дор зохион байгуулагдаж Төв аймгийн 29 төлөөлөгч сонгогдон хуралд оролцлоо.

Баян-Өнжүүл, Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 6 удирдах ажилтан, 25 багш, 283 суралцагч, 48 эцэг эхийг хамруулж салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, багш удирдах ажилтны үйл ажиллагаатай танилцлаа.

“Их, дээд сургуульд элсэгчдээс заавал авах монгол хэл, бичгийн шалгалтын босго оноог 400 байхаар тогтоосон”-ы дагуу аймгийн хэмжээнд 2 удаагийн Нэгдсэн шалгалтыг зохион байгуулав. Монгол хэл, бичгийг шалгалт-I-д 210 суралцагч шалгуулснаас 180 шалгуулагч буюу **85.7%** нь тэнцээд байна.

Албан бус насан туршийн боловсролын төвийн үйлчилгээ: Байгууллага, нэгжийн захиалгын дагуу “Монгол хэл бичгийн зөв бичих дүрэм, найруулга зүй” сургалтыг 1 байгууллагын 48, “Монгол бичгийн анхан шатны сургалт”-ыг 3 байгууллагын 73 албан хаагчид тус тус зохион байгууллаа. Мөн 9 байгууллагын 667 төрийн албан хаагчид “Харилцаа хандлага” сургалтыг зохион байгуулав.

Театрын үйлчилгээ: Тайлант хугацаанд аймгийн “Монгол туургатан театр”-аас 12 удаагийн урлаг, соёл, бусад арга хэмжээг амжилттай зохион байгуулж давхардсан тоогоор 4500 гаруй иргэд, төрийн албан хаагчид үйлчилсэн.

БНХАУ-ын зохиолч Цоа Юйгийн “НАРАН УРГАХУЙ” эмгэнэлт драмын жүжгийг шинээр найруулж, 04 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд Улаанбаатар хотын УЭДТеатрын тайзнаа тавьж 800 гаруй үзэгчдэд үйлчиллээ.

Монгол Улсын төрийн хошой шагналт, ардын жүжигчин Б.Дамдинсүрэн, Л.Мөрдорж нарын мэндэлсний 100 жилийн ойн нээлтийн арга хэмжээг Монгол Улсын консерватор Монгол туургатан театр хамтран 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Тус өдөр МУ-ын төрийн дууллын гэрэлт хөшөөний шав тавьж, Алдарын танхимын нээлт, “Төрийн сүлд мину” хүндэтгэлийн тоглолт, Их зохиолч Д. Нацагдорж, Б.Дамдинсүрэн нарын “Учиртай гурван толгой” дуурийг тоглож үзэгчдийн хүртээл болголоо.

Музейн үйлчилгээ: Тайлант хугацаанд насанд хүрэгч-401, хүүхэд-347, нийт 748 иргэнд үйлчилгээ үзүүллээ. Түүх, соёлын хөдлөх дурсгалын улсын тооллогыг 2019 оны 01 дүгээр сарын 07-оос 3 сарын хугацаатай зохион байгуулж, дүн мэдээг гаргаад байна. Тооллогоор 26 орон нутаг судлах танхим, 2 алдартны танхим нийт 1280 дэсийн 2977 ширхэг, 4336 иж бүрдэлтэй үзмэр тоологдохоос 1245 дэсийн 2903 ширхэг, 4245 ширхэг иж бүрдэлтэй үзмэр буюу **97.3%** нь хамрагдав.

Монгол Улсын Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Б.Дамдинсүрэн, Л.Мөрдорж нарын гэрэл зураг, бүтээлээр алдартны танхим тохижуулж ашиглалтад орууллаа.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: Тайлант хугацаанд нь 465 байнгын уншигч, 1449 ирэгсэд, нийт 1914 уншигчдад 4065 ном олгож уншууллаа.

Хүүхдийн уншлагын танхимын дэргэдэх Гар урлалын дугуйлангийн сурагчдыг “Шигтгээт наамал” хийх арга барилд сургаж, “Шатар”, “Англи хэл”-ний 3 дугуйланд 28 хүүхдийг хамруулав.

Уншлагын дэмжих аяны хүрээнд “Хүмүүн” цогцолбор ЕБС-тай хамтран 230 хүүхдэд сурагчдын заавал унших номыг уншин тэмдэглэл хөтлөх арга барилд сургасан. Мөн хүүхдийн номын өдрийг тохиолдуулан “Миний хайртай үлгэрийн баатар” сэдэвт гэр зургийн уралдаан зохион байгуулж, шилдгүүдээ тодрууллаа.

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Зуунмод сумын 6-н багийн зорилтот бүлгийн 12 өрхийг сонгож “Гэрийн номын сан”-тай болоход нь дэмжлэг үзүүлж, аймгийн нийтийн номын сангаас өрх бүрт 11 ширхэг ном олгож, үнэ төлбөргүй карт нээн номын сангийн үйл ажиллагаатай танилцууллаа.

Биеийн тамир, спортын үйлчилгээ: Биеийн тамирын багш, сурагчдын олимпиадыг 44 багш, 55 сурагч хамруулан амжилтай зохион байгуулав. Мөн 20 сумын 41 биеийн тамирын багш нарын дунд арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт семинарыг зохион явуулсан.

Олимп, Дэлхийн аварга алдарт бөх Роман Михайлович Дмитриевийн нэрэмжит ОХУ-ын Саха улсын Биеийн тамирын их сургуультай хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Булган аймагт зохион байгуулагдсан төвийн бүсийн аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож 1 алт, 3 хүрэл медаль, Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан самбо бөхийн өсвөр үеийн УАШТ-нд 30 кг жинд “Хүрэл” медаль хүртлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: Зорилтот бүлгийн өрхөд чиглэсэн “Гэр бүлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд давхардсан тоогоор 20 ажилтан, 22 сумын 159 өрхөөр айлчилж, нөхцөл байдлын үнэлгээ хийн өрхөд шаардлагатай үйлчилгээний хэрэгцээг тодорхойллоо.

Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг ханган, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн дуу хоолойг сонсож, тэдний санаа бодлыг хүндэтгэн үзэж, хэрэгжүүлэн ажиллах зорилгоор “Хүүхдээ сонсох” өдрийг хуваарийн дагуу сар бүр зохион байгуулан ажиллаж байна.

Ахлах ангийн сурагчдад эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аян 2019 оны 04-р сарын 15-ны өдрөөс 05-р сарын 15-ны хооронд зохион байгуулагдаж байна. “Улсын их дээд сургуулиудын талаарх мэдээллийг ахлах ангийн сурагчдад хүргэх боловсролын өдөрлөг”-ийг зохион байгуулахад Зуунмод сумын ЕБС-ийн 10-12 дугаар ангийн 540 сурагч хамрагдлаа.

Төв аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран 2019 оны 04 сарын 24-25 нд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Хуулиа дээдэлъе” тэмцээнийг 16 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, 26 сумын 27 багийн 270 сурагч оролцлоо.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: Тайлант хугацаанд /давхардсан тоо, өссөн дүнгээр/ 7237 иргэнд 1200,1 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 4490 иргэнд 284,9 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 2488 иргэнд

238,2 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 543 ахмад настанд 85,7 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 291 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 32,8 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 3499 эхэд 124,6 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Алдарт эхийн одонтой 8914 эхэд 1199.5 сая төгрөг, алдар цолтой 241 ахмад настанд 38,7 сая төгрөг, 5059 ахмад настанд 417.1 сая төгрөгийн насны хишгийг олголоо. 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 19663 эхэд 905,9 саятөгрөгийн тэтгэмж олгов.

Зуунмод сумын Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр, иргэдийн хөдөлмөрт хандах хандлагыг өөрчлөх, хүүхэд, залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгуулах зорилгоор 10 удаагийн сургалт, сурталчилгааны ажилд нийт 267 иргэдийг хамруулсан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг олгох сонгон шалгаруулалтын тендэрийг 27 суманд зарласнаас 21 сумын тендэр явагдаж, шалгарсан дэлгүүртэй хамтран ажиллах гэрээ байгуулагдсан.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 68 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 13 ажил олгогч байгууллага, 101 сул чөлөөтэй ажлын байр, 56 ажил хайгч иргэн, 63 шинэ ажлын байрыг мэдээллийн санд орууллаа.

Аргалант, Батсүмбэр, Баянцагаан, Баянцогт, Баянчандмань, Лүн, Сүмбэр, Эрдэнэсант сумын 12 бүлгийн 62 иргэнийг “Бүлгээр хүнсний ногоо тариалах арга хэмжээ”-нд хамруулж, 31,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, үр бордооны дэмжлэгт хамрагдах батламжийг гардуулсан.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: НДЕГ-ын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөр магадлах төв комиссын даргын 2019 оны 41 тоот албан бичгийн дагуу аймгийн хэмжээнд 883 хөдөлмөрийн чадвар алдсан хөгжлийн бэрхшээлтэй даатгуулагч /иргэн/-ийг “Бүрдмэл магадлалд” хамруулах ажлыг 98,3 буюу “Бүрэн хангалттай” зохион байгуулсан. Нийт ХБИ-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг хэвээр сунгасан байдал 84,6%, заалтыг өөрчилсөн 12%, цуцалсан 4%-ийн үзүүлэлттэй байна.

Тэтгэмжийн даатгалын сан болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгосон тэтгэмжийн сангийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд шалгалтыг хийгдсэн.

“Нийгмийн даатгал” аппликейшний хэрэглээг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах аяны хүрээнд 1153 иргэнд аппликейшн нээж, сурталчиллаа.

Эрүүл мэндийн үйлчилгээ: МУЗГ-ын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн нээлтийг 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгууллаа. ЭМДЕГ-тай гэрээ байгуулан ажиллаж буй “Уран дент” шүдний эмнэлгийн ажиллах цагийн хуваарийг ард иргэдэд танилцуулж, 27 сумын 2-12 насны 21891 хүүхдийн судалгаа гарган холбогдох газарт хүргүүлсэн.

“Тогтвортой хөгжлийн зорилт-2030” салбар дундын үндэсний зөвлөгөөнийг угтаж ЭМЯ-наас санаачилсан “Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” зам тээврийн ослоос сэргийлэх өдөрлөгийг улс орон даяар 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, аймгийн 26 сумын эмч, эмнэлгийн ажилчид, Зуунмод хотын хэмжээнд ЭМГ, АНЭ, ӨЭМТ-ийн 150 эмч, эмнэлгийн ажилчид нэгдэн зам тээврийн ослоос сэргийлэх уриалга, лоозон барьж тайван жагсаал хийв. Нийтийн тээвэр, таксины үйлчилгээ үзүүлэгчид болон замын хөдөлгөөнд оролцож буй нийт 200 жолоочид гарын авлага, хүүхдийг авто орслоос хамгаалах хэрэгсэл, эмийн санд байх иж бүрдлийн жагсаалтыг тараан өгч мэдээлэл хүргэсэн.

Нийгмийн эрүүл мэндийн өдрийн 2019 оны нээлтийн үйл ажиллагааг 04 дүгээр сарын 24-ний Лхагва гарагт зохион байгуулж, Зуунмод сумын хэмжээнд 26 байгууллага, 6 багийн нийт 543 ажилтан, албан хаагч оролцсон бол хөдөөгийн 11 суманд 630 иргэн оролцсон байна.

Мобайл технологийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах зорилгоор 27 сум, өрхийн ЭМТ-ийн эмч нарт 3 өдрийн онол, 2 өдрийн дадлага сургалтыг зохион байгуулав.

Нийслэлийн Зооноз өвчин судлалын төв, Улсын мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран Мөнгөнморьт сумын 6 сектор бүхий талбайд хачгийн тандалт судалгааг хийж, сургууль, цэцэрлэгийн хүүхдэд хачигт халдвараас сэргийлэх сургалтыг зохион байгуулсан. Мөн Манзушир хийд, Сэргэлэн сумын Ээж хад, хөшигтийн хөндийн орчимд тарваган тахал түүнтэй хам тохиолдох халдварын тандалтыг явууллаа.

Нүүдлийн амбулаторийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 16 сумын 21852 иргэнийг хамруулснаас өвчтэй илэрсэн 8871, эмчилгээнд оруулсан 4251, хяналтад шилжүүлсэн 313, эмчилгээг хянасан 464 өвчтөн байна.

Олон Улсын “Сувилагчийн өдөр”-ийг угтан сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд зориулсан онол практикийн хурлыг 2 үе шаттай зохион байгуулахад 1-р шатанд 29 илтгэл, 2-р шатанд шалгарсан 14 илтгэлийг дүгнэж, шилдэг 3 илтгэлийг шалгарууллаа.

АШУҮИС-тай хамтран лаборант нарт зориулсан “Элэгний өвчний үеийн орчин үеийн оношилгоо, шинжилгээ”, “Бактериологийн орчин үеийн оношилгоо, шинжилгээ” сургалтад 70 лаборант, “Вируст гепатитийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах” 3 өдрийн онол, дадлага хосолсон сургалтад 22 лаборант, 28 сувилагчийг хамруулсан.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эмнэл зүй эмгэг судлалын нэгдсэн лаборатори улсын хэмжээний 320 гаруй лабораториос 10 дахь, аймаг, орон нутгаас анхдагч лаборатори болж MNS ISO 15189:2015 Олон улсын магадлан итгэмжлэлийг 2 жилийн хугацаатайгаар авлаа.

Зургаа. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

ХАА-н чиглэлээр:

Газар тариалан: Хаврын тариалалтын бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, штабын үйл ажиллагааг 04 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлүүлсэн. Үр тариа 91,0 мян.га, үүнээс буудай 83,0 мян.га, төмс 5,8 мян.га, хүнсний ногоо 1,4 мян.га, тэжээлийн ургамал 8,5 мян.га, тосны ургамал 6,5 мян.га, жимс, жимсгэнэ 54 га-д буюу нийт 113,0 мян.га-д тариалалт хийхээр төлөвлөж, буудайн 5522 тн үр нөөцөлснөөс 90 хувийг шинжилгээнд хамруулж, стандартын шаардлага хангуулах арга хэмжээ авсан. Хаврын тариалалтад трактор 875 зүтгэх хүч, үр тарианы 687, төмсний 177, хүнсний ногооны 43 үрлэгч, сийрүүлэгч 560 ажиллахаас техникийн засвар 89 хувьтай хийгдэж, тариалалтын ажлыг 5 дугаар сарын 5-аас эхлэх бэлтгэл хангасан.

“Атрын 60-н жилийн ойн нээлт”, “Аймгийн тариалалтын зөвлөгөөн”-ийг Зуунмод суманд зохион байгуулахад ахмад-дунд-залуу үеийн тариаланч, ногоочид, агрономи, инженер, газар тариалангийн мэргэжилэн нарын төлөөлөл бүхий 300 гаруй хүн хамрагдлаа. Мөн “Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн”, “Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг тус тус зохион байгуулагдав. Ойн арга хэмжээнд зориулан “Хүндэтгэлийн туг”-ийг залж, Жаргалант сумаас эхлэн аялуулж байна. Мөн Атрын I, II, III аянд ажиллаж байсан тариаланчдыг алдаршуулах “Атарчдын талбай”-г байгуулах шав тавих ёслолын ажиллагааг зохион байгуулагдлаа.

Монгол ногоо төсөл, Борнуур сумын “Хүнсний ногооны технологи нэвтрүүлэх төв”-тэй хамтран 12 нэр төрлийн хүнсний ногооны үрийн худалдаа, Батсүмбэр сумын Поливит ХХК-тай хамтран 2 нэр төрлийн жимс, жимсгэний суулгацын худалдааг Зуунмод суманд зохион байгуулж, иргэдэд үйлчлэв.

Мал аж ахуй: Аймгийн хэмжээнд оны эхний төллөх насны хээлтэгчийн 73.4 хувь буюу 1608,6 мянган хээлтэгч мал төллөж, 1612,3 мянган төл гарсны 99.7 хувь буюу 1606,9 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 1.2 дахин буюу 225.6 мянгаар, бойжиж буй төл 1.3 дахин 231.9 мянгаар тус бүр өслөө. Оны эхний төллөх насны ингэний 45,2 хувь, гүүний 10,5 хувь, үнээний 20,7 хувь, эм хонины 77,3 хувь, эм ямааны 87,2 хувь нь тус бүр төллөөд байна. Гарсан төлийн 5451 толгой төл мал хорогдсон нь нийт бойжиж буй төлийн 0,4 хувийг эзэлж байна.

Мал аж ахуйн салбарын түр ажлын байранд 4187 хүн ажиллаж, орлогоо нэмэгдүүлсэн бөгөөд ямаа самнах-2927, хуц ухна маллах-84, төл бойжуулах-536, туслах малчин-480, оготно устгалд-160 иргэн ажилласан байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээ: Зуунмод суманд “Хөдөлмөрийн амт-2019” үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа. Тус үзэсгэлэнд 22 сумын 105 иргэн, аж ахуй нэгж 54 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 21.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Аймгийн төвийн хүн амын хэрэгцээнд зориулж мах, махан бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл гаргахгүй байх зорилгоор “Зуунмод мах боловсруулах үйлдвэр”-тэй гэрээ байгуулж, аймгийн Засаг даргын нөөц сангаас 20,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн нөөц мах худалдаалж байна.

Нийгмийн салбарын хүнсний жилийн хэрэгцээг тооцоход мах 317 тн, сүү 450 тн, төмс 316 тн, хүнсний ногоо 730 тн шаардлагатай бөгөөд эхний 4 сарын байдлаар махны хэрэгцээг 100 хувь, төмсний хэрэгцээний 83 хувь, сүүний хэрэгцээний 56 хувь, хүнсний ногооны 40 хувийг тус тус дотоодын үйлдвэрүүдээс хангалаа.

Сум хөгжүүлэх сангийн мэдээллийг цахим программд шилжүүлэн, Монгол банкны мэдээллийн санд оруулах ажлын хүрээнд зээлийн хугацаа хэтэрсэн 1043 иргэнд мэдэгдэл хүргүүлж, 653.9 сая төгрөгийн холбогдолтой 288 зээлдэгчийг Шүүхэд шилжүүлж, 153 иргэний 347,4 сая төгрөгийг төлүүлсэн.

Мал эмнэлгийн үйлчилгээ: Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 200 мян.тун буюу 200 мян.төл мал хамруулахаар 27 сумын 94 мал эмнэлэгийн үйлчилгээний нэгжүүдэд хувиарлаж, вакцинжуулалтын гүйцэтгэл 73.8 хувьтай байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төсөлтэй хамтран Өндөрширээт суманд “Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа” сургалтыг зохион байгуулж 3 сумын 16 мэргэжилтэн, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарыг хамрууллаа.

Аймаг, сумдын морин спорт уяачдын холбоотой хамтран “Алтан сав-2019” дуудлага худалдааг зохион байгуулж, 19 сумын 39 гүүнээс цусны дээжийг авч шинжилгээнд хамруулан холбогдох зөвлөгөөг өгч ажилласан.

Лүн сум дахь МЭХЦХЦ-ийн хяналтын цэг нь 318 тээврийн хэрэгсэл, адуу 935, үхэр 115, хонь 2274, ямаа 114 толгой, мах, махан бүтээгдэхүүн 74,9 тн, арьс шир 6033 ширхэг, ноолуур 88,8 тн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгосон эсэхийг шалгаж, постоор нэвтрүүлж 357 м² талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Хөрөнгө оруулалт, Худалдан авах ажиллагааны үйлчилгээ: 2019 оны 04 дүгээр сарын 28-ны байдлаар аймгийн хэмжээнд **41793,5 сая** төгрөгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Үүнд:

- Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 32434,1 сая төгрөгөөр санхүүжих 36 төсөл, арга хэмжээ байгаагаас эрх шилжин ирсэн 24466,1 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ
- Орон нутгийн хөгжлийн сангаар 2452,5 сая төгрөгөөр 24 төсөл, арга хэмжээ
- Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээр 3500,0 сая төгрөгөөр 18 төсөл, арга хэмжээ
- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 466,5 сая төгрөгийн 11 арга хэмжээ
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 718,7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс 31,3 тэрбум төгрөгийн 55 төсөл, арга

хэмжээний худалдан авах ажиллагааг зарлан 3,8 тэрбум төгрөгийн 17 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулж, 8,2 тэрбум төгрөгийн 26 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулах шатанд, 9 төсөл, арга хэмжээний үнэлгээ хийгдэж байна.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр: 2019 оны 4 дүгээр сард 4 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталж, 9 барилгын эх загвар болон ажлын зураг төслийг хянаж зөвшөөрөл олголоо. Засгийн газрын 2018 оны 68, 171 тоот тогтоолын хүрээнд 3 барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгосон.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/236 дугаар захирамжаар “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ыг батлуулсан. Журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд БАМ-ын 31, 32, 33-р байр, 5-р байр, 15-р байр, 3, 4-р байр, Мал эмнэлэг, үржлийн байр зэрэг 5 байршлын орон сууцны барилгад төсөл хэрэгжүүлэх бэлтгэл хангаж байна.

Хот, суурин газрын өнгө төрх, гэрэлтүүлэг чимэглэлийг сайжруулах зорилгоор 4 байгууллагын гадна гэрэлтүүлгийн ажлын зураглалыг “Цацрах хангай” ХХК-аар хийж гүйцэтгүүлэв.

Газрын харилцааны үйлчилгээ: Сэргэлэн-Шинэ нисэх-Зуунмод сумын харилцан уялдаа холбоотой томсгосон төлөвлөлтийн шийдэл гаргах, газрыг дахин зохион байгуулах ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамнаас зөвлөмж чиглэл авч, тус газрын иргэн аж ахуй нэгжийн судалгааг урьдчилсан байдлаар гаргасан.

Зуунмод сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийгмийн хэрэгцээ шаардлага, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хүрээнд тодотгол оруулах асуудлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьж, хэлэлцүүлэн батлууллаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/151 дугаар захирамжийн дагуу 2 нэгж талбарыг танхимын хэлбэрээр, 4 нэгж талбарыг цахим хэлбэрээр дуудлага худалдаа зохион байгуулахад нийт 12 оролцогч оролцон 5 нь ялагчаар тодорсон. 1 байршлын дуудлага худалдаанд оролцогч байхгүй тул хүчингүй болсон.

Сэргэлэн–Зуунмод сумын Хилийн цэсийн асуудлыг Зуунмод сумын багийн Иргэдийн нийтийн хурал, Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, Сэргэлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд саналаа танилцуулан, хамтарсан ажлын хэсэг гарган ажиллаж байна.

Аймгийн газрын төлбөрийн төлөвлөгөөний сар, улирлын хуваарийн дагуу 4-р сарын төлбөрийн төлөвлөгөө 180,4 сая төгрөг оруулахаас 4-р сарын 28-ны байдлаар 493,7 сая төгрөгийн орлого орж, гүйцэтгэл 274,3 хувийн биелэлттэй байна.

2019 оны 03-р сарын 17-ны А/157 тоот Аймгийн Засаг даргын захирамжаар “Татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, татварын өрийг барагдуулах” аяны хүрээнд Улаанбаатар хотод Баян, Сэргэлэн, Заамар, Баянчандмань, Батсүмбэр сумдын 97 иргэн, аж ахуй нэгж байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, 124 нэгж талбарын 1841,2 сая төгрөгийн эзэмшлийн гэрээ байгуулсан.

Байгаль орчны чиглэлээр: “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Борнуур сумын ЗДТГ-тай хамтран “Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт” сэдэвт хууль сурталчлах арга хэмжээг зохион байгуулж 83 иргэн, ААН-д ойн арчилгаа, хамгаалалт, нөхөн сэргээлт, ашиглалтын байдлын талаар сургалт мэдээлэл хийж, 18 хүүхдэд ногоон паспорт гардууллаа.

Аймгийн хэмжээнд хаврын бүх нийтийн цэвэрлэгээний өдрийг 4 дүгээр сарын 12-17 өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд уг цэвэрлэгээнд нийт 148 аж ахуйн нэгж, байгууллага, 3179 иргэн хамрагдаж 629,9 тн хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж, 419 нохой, 98 үхсэн малын сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулав.

Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй 4 сумын 26 аж ахуйн нэгж, байгууллагуудын уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн 315,6 га-д техникийн, 204,8 га-д биологийн нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулсан. Мөн аялал жуулчлал болон үйлдвэрлэл эрхлэгч 5 байгууллагатай ус ашиглах дүгнэлт, гэрээ болон байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний талаар зөвлөгөө өгсөн.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд болон дүрэм журмыг сурталчлах ажлын хүрээнд 341 сурагч, багш, ажилтанд зөвлөмж, мэдээллүүдийг өгч ажилласан.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ: Баталгаажуулалтын зөвлөлийн хурлыг 4, Баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлыг 4, нийт 8 удаагийн хурал зохион байгуулсан. Зуунмод, Батсүмбэр, Баян, Баян-Өнжүүл, Эрдэнэсант сумдын 127 худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн ажлын байранд үнэлгээ хийж “Тохирлын гэрчилгээ” хэрэглэх эрхийг 106 иргэн, аж ахуй эрхлэгчдэд олгосон.

Баян, Батсүмбэр, Эрдэнэсант, Зуунмод сумдын худалдаа, үйлчилгээний тооцоо, хүн, мал эмнэлгийн шинжилгээ, эмчилгээ оношлогоонд ашиглагдаж байгаа массын 2089, усны тоолуур 203, түгээгүүрийн хошуу 20, шингэн бүтээгдэхүүн 8, цахилгааны 1640 хэмжлийн 3 төрлөөр нийт **3960** хэмжүүр, хэмжих хэрэгслүүдийг баталгаажууллаа.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 109 дүгээр албан бичгийн дагуу “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын тайланд ХШҮ хийлээ. Үүнд 35 зорилтын 107 заалт үнэлэхэд 78.97 хувийн гүйцэтгэлтэй, 100%-51, 70%-41, 40%-12, 0-3 байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит ҮИ удаагийн үзлэгийг агентлаг, байгууллагуудад 4 дүгээр сарын 30-аас эхлэн зохион байгуулж байна.

ЗГХЭГ, Дэлхийн банкттай хамтран яам, агентлаг, 21 аймгийн ХШҮ-ний нэгжийн албан хаагчдад зохион байгуулсан “Харилцан суралцах арга зүй”-н семинарт оролцож, “Хяналт-Шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан”-ийн талаар танилцуулга хийлээ. Сургалтад оролцсон танилцуулга, мэдээллүүдийг эрэмбэлэхэд аймгийн туршлага бусад 14 аймгийн санал авч, судлагдахаар болсон.

Төв аймгийн ЗДТГ-т “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 олон улсын стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд Олон улсын стандартын академитай хамтран дотоод аудитор бэлтгэх сургалтыг зохион байгуулж, дотоод нэгжийн удирдлага, мэргэжилтэн 17 албан хаагчийг хамрууллаа. Аймгийн ЗДТГ-ын Чанарын менежментийн хорооны гишүүд болон хэлтэс, албадын төлөөллийг хамруулан “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 олон улсын стандарт нэвтрүүлсэн Сэлэнгэ аймгийн туршлага судлав.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/203 дугаар захирамжаар 2019 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны халалт, татлагын ажлыг 4 дүгээр сарын 20-29-ний өдрүүдэд 14 сумын нутаг дэвсгэрт зохион байгуулсан. Мөн аймгийн Засаг даргын 2019 оны А/212 дугаар захирамжаар аж ахуй нэгж, албан байгууллагуудын 18-50 насны ажилтан, албан хаагчдад цэргийн үүрэгтний үзлэг шалгалтыг явууллаа. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг шинээр боловсруулсан.